



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/19/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Б.Азхүү Утас: 9985-8616 Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г АРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.УНДАРМАА ТАНАА

2022.02.24 № 06
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,803,100.00	9,396,950.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,500,000.00	2,676,500.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,500,000.00	2,676,500.00
31210	Төгрөг	12,500,000.00	2,676,500.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	12,500,000.00	2,676,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,303,100.00	6,720,450.00
35100	Түүхий эд материал	1,121,000.00	1,121,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,121,000.00	1,121,000.00
35400	Хангамжийн материал	182,100.00	5,599,450.00
35410	Бичиг хэргийн материал	48,500.00	1,208,400.00
35420	Аж ахуйн материал	133,600.00	1,412,050.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	2,979,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	175,175,847.52	211,141,681.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,175,847.52	211,141,681.58
39200	Биет хөрөнгө	150,175,847.52	186,141,681.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	41,771,640.00	41,771,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,392,388.08	-2,088,582.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	121,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,613,888.86	-86,580,555.50
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	59,136,749.16	88,950,703.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,058,745.43	-17,973,233.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,727,842.15	52,797,842.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,429,641.98	-15,325,652.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,447,600.00	14,447,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,113,319.44	-11,558,079.36
39300	Биет бус хөрөнгө	25,000,000.00	25,000,000.00
39301	Программ хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-715,000.00	-715,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,000,000.00	25,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	188,978,947.52	220,538,631.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,500,000.00	2,676,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,500,000.00	2,676,500.00
41400	Урьдчилж орсон орлого	12,500,000.00	2,676,500.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	12,500,000.00	2,676,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	176,478,947.52	217,862,131.58
51	Засгийн газрын хувь оролцоо	176,478,947.52	217,862,131.58
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	193,926,546.00	193,926,546.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-21,340,358.48	20,042,825.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-45,098,360.28	-21,340,358.48
51220	Тайлант үеийн үр дүн	23,758,001.80	41,383,184.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,892,760.00	3,892,760.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	188,978,947.52	220,538,631.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	522,727,887.31	725,748,014.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,494,187.31	40,773,714.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,494,187.31	40,773,714.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	34,494,187.31	35,794,714.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	4,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,233,700.00	684,974,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	477,498,700.00	682,974,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	477,498,700.00	682,974,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,735,000.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,735,000.00	2,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	498,969,885.51	684,364,829.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498,969,885.51	684,364,829.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,539,885.51	651,472,608.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,863,824.00	456,755,747.78
210101	Үндсэн цалин	283,809,707.00	390,260,928.57
210102	Нэмэгдэл	51,841,117.00	57,048,419.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,213,000.00	9,446,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,045,848.00	57,114,526.00
210201	Тэтгэврийн даатгал	30,116,948.00	40,674,928.21
210202	Тэтгэмжийн даатгал	3,447,700.00	4,405,908.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,200.00	2,991,888.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,669,900.00	822,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,387,100.00	8,219,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,705,800.00	26,198,505.00
210301	Гэрэл, цахилгаан	4,633,851.00	5,866,629.00
210302	Түлш, халаалт	21,280,049.00	18,578,414.00
210303	Цэвэр, бохир ус	3,791,900.00	1,753,462.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,639,629.00	50,529,602.00
210401	Бичиг хэрэг	25,316,710.00	14,098,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,889,670.00	11,480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,176,800.00
210404	Ном, хэвлэл	16,300.00	204,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,700.00	7,872,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,113,249.00	10,698,142.00
2105	Нормативт зардал	65,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,181,400.00	11,236,000.00
210604	Урсгал засвар	7,181,400.00	11,236,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,763,700.00	3,317,900.00
210702	Дотоод албан томилолт	1,763,700.00	3,317,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,038,730.00	11,269,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,465,730.00	10,612,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,200.00	104,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,800.00	140,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	253,000.00
210807	Газрын төлбөр	61,000.00	115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,235,954.51	35,050,927.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	2,512,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,070,548.00	7,710,008.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,965,406.51	24,828,879.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,430,000.00	32,892,221.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,430,000.00	11,976,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	11,476,300.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,430,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	20,915,921.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	20,915,921.22
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	23,758,001.80	41,383,184.06
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	23,758,001.80	41,383,184.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	193,926,546.00	3,892,760.00	-21,340,358.48	176,478,947.52
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	193,926,546.00	3,892,760.00	-21,340,358.48	176,478,947.52
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	193,926,546.00	3,892,760.00	-21,340,358.48	176,478,947.52
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	41,383,184.06	41,383,184.06
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	193,926,546.00	3,892,760.00	20,042,825.58	217,862,131.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	498,733,700.00	685,650,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,500,000.00	676,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,500,000.00	676,500.00
120009	Бусад орлого	10,500,000.00	676,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,233,700.00	684,974,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	477,498,700.00	682,974,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	477,498,700.00	682,974,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,735,000.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,735,000.00	2,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	480,933,700.00	670,474,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	480,933,700.00	670,474,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,503,700.00	627,082,078.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,178,500.00	456,581,673.78
210101	Үндсэн цалин	254,312,500.00	318,521,200.00
210102	Нэмэгдэл	78,419,600.00	128,614,073.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,446,400.00	9,446,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,390,000.00	57,288,600.00
210201	Тэтгэврийн даатгал	31,461,100.00	40,849,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,232,200.00	4,109,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,585,800.00	3,287,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	646,400.00	822,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,464,500.00	8,219,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,705,800.00	26,198,505.00

Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	4,633,851.00	5,866,629.00
210302	Түлш, халаалт	21,280,049.00	18,578,414.00
210303	Цэвэр, бохир ус	3,791,900.00	1,753,462.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,122,900.00	39,977,700.00
210401	Бичиг хэрэг	20,905,000.00	15,462,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,630,000.00	9,480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,210,900.00
210404	Ном, хэвлэл	183,700.00	424,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,850,000.00	3,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,554,200.00	4,900,000.00
2105	Нормативт зардал	65,000.00	1.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	1.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,400,000.00	11,236,000.00
210604	Урсгал засвар	7,400,000.00	11,236,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,763,700.00	3,317,900.00
210702	Дотоод албан томилолт	1,763,700.00	3,317,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,247,800.00	16,681,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,674,800.00	16,025,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	1.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,200.00	104,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,800.00	140,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	253,000.00
210807	Газрын төлбөр	61,000.00	115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,630,000.00	15,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	4,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,130,000.00	11,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,430,000.00	43,392,221.22
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	10,500,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	10,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,430,000.00	11,976,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	11,476,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,430,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	20,915,921.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	20,915,921.22
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,800,000.00	15,176,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,300,000.00	25,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,300,000.00	25,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,300,000.00	25,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,300,000.00	25,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,300,000.00	-25,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,500,000.00	-9,823,500.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,000,000.00	12,500,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,500,000.00	2,676,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	682,974,300.00	662,058,378.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,974,300.00	662,058,378.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,998,000.00	650,082,078.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,316,400.00	456,581,673.78
210101	Үндсэн цалин	318,521,200.00	318,521,200.00
210102	Нэмэгдэл	140,348,800.00	128,614,073.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,446,400.00	9,446,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,288,600.00	57,288,600.00
210201	Тэтгэврийн даатгал	40,849,000.00	40,849,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,109,900.00	4,109,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,287,900.00	3,287,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	822,000.00	822,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,219,800.00	8,219,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,379,700.00	26,198,505.00
210301	Гэрэл, цахилгаан	6,506,400.00	5,866,629.00
210302	Түлш, халаалт	24,600,000.00	18,578,414.00
210303	Цэвэр, бохир ус	4,273,300.00	1,753,462.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,977,700.00	37,977,700.00
210401	Бичиг хэрэг	13,462,500.00	13,462,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,480,000.00	9,480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,226,000.00	6,210,900.00
210404	Ном, хэвлэл	409,200.00	424,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,000.00	4,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,236,000.00	36,236,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00
210602	Тавилга	16,000,000.00	16,000,000.00
210604	Урсгал засвар	11,236,000.00	11,236,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,317,900.00	3,317,900.00
210702	Дотоод албан томилолт	3,317,900.00	3,317,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,681,700.00	16,681,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,025,000.00	16,025,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	104,000.00	104,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,700.00	140,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	115,000.00	115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,800,000.00	15,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	11,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,976,300.00	11,976,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,976,300.00	11,976,300.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,476,300.00	11,476,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	682,974,300.00	662,058,378.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	682,974,300.00	662,058,378.78
310001	Улсын төсвөөс санхүүжих	682,974,300.00	662,058,378.78
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12
620003	Үйлчлэх ажилтан	8	8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650012	Шүүгч, прокурор	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,000,000.00
2132	Хангамж, бараа материалын зардал	2,000,000.00
213209	Бичиг хэрэг	2,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд тээвэр, шатахууны зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/158 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Прокурорын газар нь “Прокурорын тухай” хуулийн 42.1-д заасны дагуу Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Аймгийнхаа нутаг дэвсгэрт эрүүгийн хуулийн тогтоомжийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагааг төрийн нэрийн өмнөөс явуулж бие даасан хараат бус байдлыг эрхэмлэж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж зөрчигдсэн эрхийг нь сэргээх төр нийгэм, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлж, шударга ёсыг сахиулахад оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Прокурорын тухай хуулийн 46.8. Энэ хуулийн 46.1, 46.2-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо зохион байгуулна” гэж 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс 2021 оны эхний 8 сарын байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэллээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 682.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 31.6 сая төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	12.5	2.6	(9.9)	(79.2)
Бараа материал	1.3	6.7	5.4	415.3
Үндсэн хөрөнгө	175.1	211.1	36.0	20.5
Нийт хөрөнгө	188.9	220.5	31.6	16.7
Өр төлбөр	12.5	2.6	(9.9)	(79.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	176.4	217.8	41.4	23.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	188.9	220.5	31.6	16.7

3.5.1. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 415.3 хувиар өссөн байна..

Бараа материалын данс нь 1.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 62.4 төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 4.9 сая төгрөг нийт 67.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 61.9 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 20.5 хувиар өссөн байна..

Үндсэн хөрөнгө данс нь 175.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 25.0 сая төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй 35.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, тайлант хугацаанд байгуулсан 24.8 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 211.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Өр төлбөр данс нь 2.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй нь барьцаа хөрөнгийн дансны өглөг байна.

3.5.4. Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 16.7 хувиар өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 607.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 75.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 682.9 сая төгрөгөөр хянаж баталсан нь 2 прокурор, 1 бичиг хэрийн ажилтны орон тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 682.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 672.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 20.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 9.1 сая, цалингийн зардлаас 11.8 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар Архангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2021.11.30-ны өдрийн тушаалаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн зардалд 2.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх брошур хэвлүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас өгсөн чиглэлийн дагуу прокурор, ажилтнуудыг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах, цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмчилгээний дараах эрсдэлийг арилгах зорилгоор нэг удаагийн хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан байна.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2019.12.05-ны өдрийн 346, А/80 дугаар тушаалаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-аар барьцааны мөнгийг байгууллагын төрийн сан дахь харилцах дансанд байршуулдаг онцлог ажил гүйлгээтэй байна. Тайлант оны эхний үлдэгдэл 12.5 сая төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 2.6 сая төгрөг байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 682.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 672.5 сая төгрөгийг зарцуулж, 98.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Прокурорын байгууллага нь төрийн тусгай чиг үүргийн байгууллага тул ЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд хамаарахгүй бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: NissanPairol маркийн авто машин нь 2011 онд үйлдвэрлэсэн 67.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 2.0 сая төгрөг, RENAULT DUSTER маркийн авто машин нь 2019 онд үйлдвэрлэгдсэн 53.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 9.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 10.8 сая төгрөгийг олгожээ. Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Прокурорын газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Бусад мэдээллийг бүрэн оруулсан байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалтыг нормоор тооцон олгож байгаа эсэхэд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Аудитаар Архангай аймгийн Прокурорын газрын албан хэрэгцээнд ашиглагддаг Дастер маркийн 88-00 APX улсын дугаартай автомашин нь 2021 онд зарцуулсан шатахууны зарцуулалтын тооцоог шалгахад нормоос 0.6 сая төгрөг илүү зарцуулсан зөрчил илэрлээ. Иймд зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлээ.

-----oO-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Прокурорын газар	1	0.6					1	0.6		